



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Б.БАТЦЭЦЭГ

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 28-ны өдрийн 45 дугаар
тогтоолын хавсралт



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН
ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Гадаад харилцааны яам (цаашид “яам” гэх)-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-т Засгийн газрын танхим, Гадаад харилцааны сайд (цаашид “сайд” гэх)-аас шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн гадаад улс төр, олон улсын эдийн засаг, хүмүүнлэгийн болон бусад салбарын хамтын ажиллагааны бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, улсын хэмжээнд нэгдсэн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтаар хангах, олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, консулын үйлчилгээ үзүүлэх, хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашиг, ашиг сонирхлыг хамгаалах, монгол сургууль, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх, гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах асуудлыг хамааруулан яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн загварыг тодорхойлов.

1.2.Үндэслэл

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэтгэлийн талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн боловсруулав.

1.3.Хууль, эрх зүйн орчин

1.3.1.Хөтөлбөрийг доор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Дипломат албаны тухай хууль;

- Олон улсын гэрээний тухай хууль;
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Дипломат харилцааны тухай Венийн конвенц;
- Консулын харилцааны тухай Венийн конвенц;
- Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц;
- Авлигын эсрэг хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- бусад холбогдох хууль тогтоомж.

1.4.Арга зүй


Хөтөлбөрийг гадаад харилцааны салбарт бий болсон түүхэн туршлага, олон улсын жишиг, гадаад орчны өөрчлөлт, төрийн захиргааны шинэчлэл, удирдлага болон үйл ажиллагааны онцлог, төлөвлөлт, зохицуулалтын нийтлэг арга зүйг ашиглан боловсруулав.

1.5.Яамны үүрэг, хариуцлагын хуваарь

Яам нь гадаад харилцааны талаарх Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж, Засгийн газрын танхим, сайдыг цаг үеэ олсон мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, дэмжлэгээр хангана. Яам нь гадаад бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зөв зохистой удирдан зохицуулна. Яам нь хариуцсан асуудлаар Засгийн газрын зөвлөхийн үүрэг хүлээж, яамд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтаар хангана. Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой,

бүрэн тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох үндэслэл болно. Энэ хэрэгцээний эх үүсвэрт доор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарна.

Гадаад харилцааны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Засгийн газрын танхим, Гадаад харилцааны сайд байх бөгөөд шууд бус үйлчлүүлэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар, дотоод, гадаадын байгууллага, иргэн байна. Яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх бүх төрлийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Хоёр. Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар сайдын үйл ажиллагаанд цаг үеэ олсон мэргэжлийн өндөр түвшний, алсын хараатай, шуурхай зөвлөгөөгөөр хангаж, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны стратегийн гадаад орчин

Олон улсын харилцааны чиг хандлагууд нь Монгол Улсын гадаад орчинд урт хугацаанд нөлөөлж, төрийн гадаад бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход зайлшгүй харгалзан үзэх хүчин зүйл болж байна.

Олон улсын харилцаанд үүссэн нөхцөл байдал зэвсэгт мөргөлдөөн, дэлхийн улс орнууд талцан хуваагдсан байдал урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа өнөөгийн нөхцөлд Монгол Улсын байр суурийг оновчтой тодорхойлж, гадаад бодлогын залгамж чанар, нэгдсэн зохицуулалтыг хангах нь чухал ач холбогдолтой юм.

Мэдээлэл, харилцаа холбооны технологи хурдацтай хөгжихийн хэрээр гадаад харилцааны субъектүүдийн хүрээ өргөжин тэлж байна. Аюулгүй байдлын уламжлалт утга өөрчлөгдөн улам олон салбар, өргөн хүрээг хамрах болж, терроризмын уламжлалт бус аюул, занал нь дэлхийн, бүс нутгийн болон улс орнуудын тулгамдсан, хамтран шийдвэрлэх асуудал болж хувирав.

Хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх, эдийн засгийн хориг арга хэмжээ, хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүний хяналттай холбоотой үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэх, гадаад улс төр, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг зорилтууд тус яамны өмнө тавигдаж байна.

2.3. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Гадаад харилцааны яам нь үйл ажиллагааны доор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.3.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах таатай гадаад орчныг бүрдүүлэх;

2.3.2. Олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монгол Улсын хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх;

2.3.3. Хүмүүнлэгийн харилцааг хөгжүүлэх, хилийн чанад дахь монгол иргэд, сургууль, цэцэрлэг, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх;

2.3.4. Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хилийн чанадад хамгаалах.

2.4. Гадаад харилцааны яамны эрхэм зорилго нь Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчныг бүрдүүлэхэд оршино.

Энэхүү эрхэм зорилгыг биелүүлэхдээ Монгол Улсын гадаад харилцааг үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон зарчим, чиглэлээр улс орны болон дэлхий дахины улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тууштай хэрэгжүүлж, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогыг идэвхтэй явуулах, гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг эрхэмлэж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал,

олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлэх, олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг тууштай дэмжих, хилийн чанад дахь монгол иргэд, сургууль, холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх зорилтуудыг удирдлага болгоно.

2.5. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Яам нь тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны стратегийн доор дурдсан зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ:

2.5.1. гадаад бодлогыг нэгдсэн төлөвлөлт, удирдамжаар хангах;

2.5.2. гадаад бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах;

2.5.3. хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;

2.5.4. гадаад бодлогын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ, дотоод аудит хийх.

2.6. Үйл ажиллагааны гол зорилт

Яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

2.6.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1. гадаад бодлого, урт, дунд, богино хугацааны стратегийн төслийг боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангах;

2.6.1.2. улсын хэмжээнд гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтаар хангах.

2.6.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1. хөрш орнууд, "Гуравдагч хөрш" зэрэг бусад орнуудтай бүх талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

2.6.2.2. олон талт хамтын ажиллагааны бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

2.6.2.3. олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжилтийг хангах, зохицуулах;

2.6.2.4. Консулын албаны бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

2.6.2.5. олон улсын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, олон улсын эрх зүйн асуудлаар байр суурь тодорхойлох, санал боловсруулах, зөвлөмж өгөх;

2.6.2.6. ёслолын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах.

2.6.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1.сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргаас шийдвэр гаргахад шаардлагатай хууль, эрх зүй, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаагаар хангах, бүх талын дэмжлэг үзүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, захиргааны удирдлагаар хангах;

2.6.3.2.хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.6.3.3.хууль дээдлэх ёсыг хэвшүүлэх, ил тод байдлыг дэмжих, удирдлагаар хангах;

2.6.3.4.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, шилэн дансны хуулийг мөрдүүлэх, хяналт тавих;

2.6.3.5.гадаад харилцааны төв архивын үйл ажиллагааг эрхлэх.

2.6.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.4.1.сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж үнэлгээ өгөх, зөвлөмж боловсруулах.


2.7. Үйл ажиллагааны зорилт

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны зорилтын хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.8. Үйл ажиллагааны стратегийн загвар

Яамны үйл ажиллагааны стратегийн загварыг доор дурдсанаар тодорхойлж байна:

Гадаад харилцааны яамны үйл ажиллагааны ерөнхий загвар



Гурав.Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн чиг үүрэг

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

3.1.1.яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх (яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо буюу зохион байгуулалтын бүтэц нь энэхүү хөтөлбөрийн үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдаж боловсруулагдсан);

3.1.2.эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх (яамны бүтцийн нэгж тус бүрийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхой заагласан бөгөөд зохион байгуулалтын бүтцэд удирдах, гүйцэтгэх албан тушаалын шатлан захирах ёсны зарчим бүрэн хангагдсан, мөн бусад төрийн байгууллагуудын чиг үүрэгтэй давхардахгүй байгаа болно);

3.1.3.үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх (хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцээс яамны үйл ажиллагааны чиглэл, хэрэгжилтийг нь хангах хууль тогтоомжийн талаар болон зохион байгуулалтын нэгж тус бүрийн нэршлээс гүйцэтгэх чиг үүргийг шууд дүгнэх боломжтой);

3.1.4.бүтцийн хувьд энгийн байх (яамны Төрийн нарийн бичгийн даргаас албан хаагч хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байна);


3.1.5.тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоосон байх (яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар хялбар аргаар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх байдлаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүний болон бусад нөөцийг зөв хуваарилан, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байна);

3.1.6.улс төрөөс ангид байх (яамны албан хаагчид нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх мэдлэг, туршлагатай, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан байна);

3.1.7.хангалттай чадавхтай, бодитой үйл ажиллагаатай байх (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь үйл ажиллагааны давхардалгүй, чадавхаа бүрэн дүүрэн илрүүлэх, дайчлан ажиллахад чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байна).

3.2. Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо дараах загвартай байна:



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Яамны үйл ажиллагааны стратегийн загвараас зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж байна.

3.3.1. бодлогын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь гадаад бодлогын нэгдсэн төлөвлөлт, зохицуулалт, удирдамжаар хангахад Гадаад харилцааны сайдад дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж, гадаад бодлого, урт, дунд, богино хугацааны стратегийн төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, улсын хэмжээнд гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааны хэрэгжилт, үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах, гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаатай холбогдох гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, хэлэлцээ хийх, байгуулах ажлыг уялдуулан зохион байгуулах, яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээний төлөвлөгөө болон Засгийн газрын

гишүүдийн айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь гадаад бодлого, олон улсын харилцааны тодорхой асуудлаарх Монгол Улсын байр суурийг тодорхойлох, Гадаад харилцааны яамны үйл ажиллагааг Улсын Их Хурал, Засгийн газар болон бусад төрийн болон орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах, шуурхай хэлхээ холбоог хангах, гадаад бодлого, бүс нутаг, олон улсын харилцааны асуудлаарх Монгол Улсын байр суурийг тодорхойлох ажлыг яамны хэмжээнд зохион байгуулах, яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, өндөр дээд түвшний айлчлалын төлөвлөгөөг гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаж буй эсэхэд дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулах зэрэгт чиглэгдэнэ. Мөн энэ нэгж нь Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, Засгийн газрын танхимыг сайдын эрхлэх асуудлын хүрээний талаарх шаардлагатай мэдээллээр хангах, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх бүх шатанд тайлбар, зөвлөгөө, лавлагаа өгөх, сайдаас Улсын Их Хурлын чуулганд хийх мэдээлэл болон Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулт, асуулгын хариултын төслийг бэлтгэх зэргийг зохион байгуулна. Мөн энэ нэгж нь дипломат албаны үйл ажиллагааг нийтэд мэдээлэх, яамны цахим хуудсанд тавих мэдээллийг бэлтгэх, хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай харьцах, тэднийг яаманд болж байгаа арга хэмжээг сурталчлах ажилд оролцуулах болон хэвлэлийн бага хурал хийх ажлыг зохион байгуулах, дотоод гадаадын өдөр тутмын хэвлэлийн тойм бэлтгэж яамны удирдлага, ажилтнуудад түгээх, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, яамд, Засгийн газрын агентлаг, Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, шууд бус хэрэглэгч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар болон бусад хэрэглэгч байна.

3.3.2. хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг.

Эдгээр нэгж нь гадаад улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийг төрөлжсөн зохицуулалтаар хангах үндсэн үүрэг хүлээж, тодорхой бүс нутгийн улс орнууд болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.2.1. хөрш орнуудтай харилцах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг хангах үндсэн үүргийг хүлээж, Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхдээ доор дурдсан нийтлэг чиг үүрэг, үйл ажиллагааг эрхлэн явуулна:

-хөрш орнуудтай бүх талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хэмжээг зохих түвшинд байлгах, харилцааны үр ашгийг нь дээшлүүлэх;

-улс төр, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, батлан хамгаалах зэрэг бүх салбарын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох;

-хоёр талын харилцааны асуудлаар бүс нутгийн болон дэлхий нийтийн хөгжлийн хандлага, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газрын байр суурийг боловсруулах;

-хөрш орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг бодлогын удирдамж, чиглэлээр хангах, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх.

3.3.2.2.Америк, Ойрхи Дорнод, Далайн орнуудтай харилцах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь Монгол Улсаас Америк, Ойрхи Дорнод, Далайн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг хангах үндсэн үүргийг хүлээж, Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхдээ доор дурдсан нийтлэг чиг үүрэг, үйл ажиллагааг эрхлэн явуулна:

-тухайн бүс нутгийн орнуудтай бүх талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийн түвшинд хүргэх, худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх, харилцааны үр ашгийг нь дээшлүүлэх;

-улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, батлан хамгаалах зэрэг бүх салбарын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох;

-хоёр талын харилцааны асуудлаар бүс нутгийн болон дэлхий нийтийн хөгжлийн хандлага, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газрын байр суурийг боловсруулах;

-Монгол Улсаас Америк, Ойрхи Дорнод, Далайн орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг удирдан, бодлогын удирдамж, чиглэлээр хангаж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх.

3.3.2.3.Азийн орнуудтай харилцах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь Монгол Улсаас Азийн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг хангах үндсэн үүргийг хүлээж, Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхдээ доор дурдсан нийтлэг чиг үүрэг, үйл ажиллагааг эрхлэн явуулна:

-тухайн бүс нутгийн орнуудтай бүх талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийн түвшинд хүргэх, худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх, харилцааны үр ашгийг нь дээшлүүлэх;

-улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, батлан хамгаалах зэрэг бүх салбарын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох;

-хоёр талын харилцааны асуудлаар бүс нутгийн болон дэлхий нийтийн хөгжлийн хандлага, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газрын байр суурийг боловсруулах;

-Азийн орнуудад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг удирдан, бодлогын удирдамж, чиглэлээр хангаж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх.

3.3.2.4.Европ, Африкийн орнуудтай харилцах асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь Монгол Улсаас Европ, Африкийн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг хангах үндсэн үүргийг хүлээж, Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхдээ доор дурдсан нийтлэг чиг үүрэг, үйл ажиллагааг эрхлэн явуулна:

-тухайн бүс нутгийн орнуудтай бүх талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийн түвшинд хүргэх, худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх, харилцааны үр ашгийг нь дээшлүүлэх;

-улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, батлан хамгаалах зэрэг бүх салбарын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох;

-хоёр талын харилцааны асуудлаар бүс нутгийн болон дэлхий нийтийн хөгжлийн хандлага, улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газрын байр суурийг боловсруулах;

-Европ, Африкийн орнуудад суугаа Дипломат төлөөлөгчдийн газруудын үйл ажиллагааг удирдан, бодлогын удирдамж, чиглэлээр хангаж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх.

3.3.2.5.олон талт хамтын ажиллагааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь Монгол Улсаас Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн болон олон улсын Засгийн газар хоорондын бусад байгууллага, олон улс, бүс нутгийн яриа хэлэлцээний механизмын хүрээнд явуулах бодлогыг боловсруулах, олон талт үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үндсэн үүргийн хүрээнд доор дурдсан чиг үүрэг, үйл ажиллагааг эрхлэн явуулна:

-Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын бусад байгууллагатай улс төр, нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн бүхий л салбарт харилцах өдөр тутмын ажлыг гүйцэтгэж, тэдгээрийн өмнө манай улсын хүлээсэн үүргийг биелүүлэх;

-олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах чигийг тодорхойлж, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх;

-олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, тэдгээрийн шугамаар зохиогдож байгаа хурал, чуулганд төлөөлөгчид оролцуулах, баримтлах удирдамж боловсруулах, байр сууриа илэрхийлэх;

-бүс нутаг, олон улсын аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хамтын ажиллагаанд манай улсын оролцоог нэмэгдүүлэх;

-Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагуудын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газруудын үйл ажиллагааг удирдан бодлогын удирдамж, чиглэлээр хангаж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх.

Хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар болон бусад хэрэглэгч байна.

3.3.2.6. олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь гадаад орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

-Олон талт худалдааны тогтолцоо, Дэлхийн худалдааны байгууллагын үйл ажиллагаанд Монгол Улсын идэвхтэй оролцоог хангах, байр суурь, нэр хүнд, ашиг сонирхлыг хамгаалах;

-Гадаад орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;

-Эдийн засгийн хориг арга хэмжээ, хоёрдмол зориулалттай бараа бүтээгдэхүүний хяналттай холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

-Олон улсын худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай харилцах, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллах;

-Олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, урт, дунд, богино хугацааны стратеги, үндсэн чиглэлийг гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх, зохицуулах;

-Олон улсын төлбөр тооцоо, ханган нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх үүднээс холбогдох улс орнуудтай хамтран ажиллах, дотоодын байгууллагуудын уялдааг хангах.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон аж ахуйн нэгжүүд байна.

3.3.2.7.консулын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь консулын албаны бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, иргэд, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд консулын үйлчилгээг шуурхай хүргэх, хилийн чанад дахь Монгол Улсын иргэд, харьяат, уугуул иргэд, хувийн хэвшлийн эрх ашиг, ашиг сонирхлыг хамгаалах, иргэдэд туслах сангийн ажлыг хариуцах, хилийн чанадад зорчиж байгаа монгол иргэд болон хилээр нэвтэрч байгаа гадаад, дотоод иргэдийн бүртгэл, судалгааг хийх, нэгтгэх, консулын асуудлаар байгуулагдсан гэрээ, хэлэлцээр, протоколын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, иргэд хилийн харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, дипломат, албан зэргийн виз олгох, гадаадын иргэдийн асуудлыг Монгол Улсын нутаг дэвсгэрт зохицуулах, тэдэнд консулын үйлчилгээ үзүүлэх, нотариатын үйл ажиллагаа явуулах, консулын тайлан гаргах, хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Өргөмжит консулуудыг консулын холбоотой асуудлаар мэргэжлийн удирдлага, бодлогын удирдамж, чиглэлээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, үйлчилгээ үзүүлэх хэрэглэгч нь Монгол Улсын иргэд, гадаад орнуудаас Монгол Улсад зорчиж байгаа иргэд, консул, Өргөмжит консул байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Монгол Улсаас гадаад оронд суугаа Дипломат төлөөлөгчийн газар Өргөмжит консул, Монгол Улсад суугаа гадаад орны Дипломат төлөөлөгчийн газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар, төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байна.

3.3.2.8.гэрээ, эрх зүйн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь олон улсын гэрээ, эрх зүйн бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хүний эрх болон хилийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээж, олон улсын гэрээ, эрх зүйн бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, зохицуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагааны бодлого, зорилтыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хоёр болон олон талт бүхий л салбарын гэрээний төсөл боловсруулах, байгуулахад эрх зүйн дэмжлэг үзүүлэх, олон улсын гэрээнд нэгдэн орох асуудлыг судалж санал боловсруулах, нэгдэн орсон гэрээний биелэлтийн тухай илтгэл, мэдээлэл нэгтгэн боловсруулж гаргах, түүнчлэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн олон улсын гэрээнд нэгдэн орох, хэрэгжилтийн тайланг нэгтгэж гаргах, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах ажлыг үндэсний хэмжээнд аргачлал, хяналтаар хангах, хэлэлцээ хийх, ёсчлон бэлтгэх, батлуулах, бүртгэх, архивд хадгалуулах, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээний эрх зүйн уялдааг хангах, орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний бүртгэл хөтлөх, хэвлэн нийтлүүлэх, биелэлтэд нь ерөнхий хяналт тавих, олон улсын эрх зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгж нь хилийн асуудал эрхэлсэн нэгжтэй байна. Хилийн асуудал хариуцсан нэгж нь хөрш орнуудтай хил, хилийн дэглэм, хилийн боомтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн харилцааны гэрээний биелэлтийг хангуулах, хил орчмын тулгамдсан асуудлыг эрх зүйн хүрээнд зохицуулах, улсын хил шалгалтын ажилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулна.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, яамд, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар, төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, бусад холбогдох яамд, Засгийн газрын агентлаг байна.

3.3.2.9.ёслолын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг;

Энэ нэгж нь ёслолын бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд нарын гадаад оронд хийх албан ёсны айлчлал болон гадаадын дээд, өндөр хэмжээний зочин төлөөлөгчдийн айлчлалын бэлтгэлийг хангах, гадаадын Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нар Монгол Улсын Ерөнхийлөгчид Итгэмжлэх жуух бичгээ барих, гадаадын зочин төлөөлөгчид төр, засгийн удирдагч нарт бараалхах, Улаанбаатар дахь Дипломат төлөөлөгчийн газруудын эрх ямба, халдашгүй дархан эрхтэй холбогдсон асуудал, дипломат корпусыг баяр ёслолын арга хэмжээнд урьж оролцуулах зэрэг дипломат ёслолтой холбогдсон харилцааны талаар зөвлөгөө өгөх, зохицуулах, үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн ёслолын алба, тэдгээрийн ажилтнууд, төрийн хамгаалалтын ажилтнууд байна.

3.3.3.Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үндсэн үүрэг хүлээж, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргаас шийдвэр гаргахад шаардлагатай хууль, эрх зүй, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаагаар хангах, бүх талын дэмжлэг үзүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, захиргааны удирдлагаар хангах, хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргаанд хууль дээдлэх ёсыг хэвшүүлэх, ил тод байдлыг дэмжих, удирдлагаар хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, шилэн дансны хуулийг мөрдүүлэх, хяналт тавих, гадаад харилцааны төв архивын үйл ажиллагааг эрхлэх, салбарын мэдээллийн технологийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд доор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ:

-хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, мерит тогтолцоог нэвтрүүлэх, гүйцэтгэлийн бодит, найдвартай шалгуур үзүүлэлтийг боловсруулах, төгөлдөржүүлэх, сурталчлах, хөтөлбөр хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

-сайдаас гаргах шийдвэр болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулалтад бүх талын дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, яамны үйл ажиллагааг төсөвтэй уялдуулах;

-хилийн чанадад байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар, үл хөдлөх хөрөнгө авах, түрээслэх, Улаанбаатар болон бусад хот, аймгийн төвд гадаадын Дипломат төлөөлөгчийн газар байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэдгээрт газар олгох, үл хөдлөх хөрөнгө авах бололцоог урт, богино хугацаагаар төлөвлөн мэдээлэх, газрыг тусгай хэрэгцээнд авах, Дипломат төлөөлөгчийн газрын байрны үйлчилгээний асуудлыг хүлээн авч шийдвэрлэх, газар, үл хөдлөх хөрөнгийн төлбөрөөс харилцан чөлөөлөх хэлэлцээр байгуулах асуудлыг санаачлан яриа хэлэлцээ явуулах;

-яамны үйл ажиллагаанд орчин үеийн техник технологи нэвтрүүлэх, аюулгүй байдлыг хангах, төрийн нууцыг хадгалах, хамгаалах, бичиг харилцааны хөтлөлтийг эрхлэх, яамны нэгжүүдийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдэнд бүх талын дэмжлэг үзүүлэх, яамны үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтын тэргүүний туршлага, шинэлэг арга барилыг нэвтрүүлэх;

-албан тушаалын тодорхойлолтыг гаргах, гүйцэтгэлийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, хөдөлмөрийн сахилга бат, дотоод дэг журмыг чанд мөрдүүлэх, мэдээ тайланг гаргуулах, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох тогтолцоог оновчтой бүрдүүлэх, хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, албан хаагчдын давтан сургалтын тогтолцоог бүрдүүлэх, дотоод сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

-Дипломат төлөөлөгчийн газар болон төр, засгийн байгууллага хоорондын харилцааг дэмжих чиглэлээр нэгдсэн зохицуулалт, үйлчилгээгээр хангах.

Энэ нэгжийн зарим чиг үүргийн хүрээнд гадаад харилцааны төв архив ажиллана. Гадаад харилцааны төв архив нь архивын бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах, байгууллага, иргэдэд архивын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой болон тус яамны үйл ажиллагааны явцад үүсэж бүрдсэн баримт бичгүүдийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн хадгалах, түүх, улс төр, эдийн засаг, эрдэм шинжилгээний ач холбогдолтой материалуудыг цуглуулах, сан хөмрөгийг бүрдүүлэх, баяжуулах, хосгүй үнэт баримт бичгүүдийг сэлбэн засах, нөхөн сэргээх, тоо бүртгэл хөтлөх, эрдэм шинжилгээ, мэдээллийн лавлагааны сан үүсгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, сайдын эрхлэх ажлын хүрээний байгууллага, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсад суугаа гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар, иргэд болон хуулийн этгээд байна.

3.3.4. хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг.

Энэ нэгж нь гадаад бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хууль тогтоомж, гадаад улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны бодлого, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээний үр дүнд тулгуурлан санал үндэслэл боловсруулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж үнэлгээ өгөх, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь гадаад харилцаанд холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд гадаад харилцааны талаар тусгагдсан зорилт, арга хэмжээ, Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үнэлгээний мэдээллийн системд байршуулж, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, яамны нээлттэй, ил тод, шударга байдлын үнэлгээг хийж, тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг холбогдох нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг хугацаандаа байршуулж байгаа эсэхэд хяналт тавьж, хариуцсан асуудлаар Дипломат төлөөлөгчдийн газруудыг удирдлага заавраар хангаж үйл ажиллагааг нь үнэлэн дүгнэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжийн үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.